

Хэсэг 3

Эдийн засгийн өрнөл ба улс төрийн замнал¹

Мигэддоржийн Батчимэг

Редакторын тайлбар: Засгийн газрын өндөр тушаалтан тухайлбал Ерөнхийлөгчийн Үндэсний Аюулгүй байдлын зөвлөх өөрийн өгүүллийг хэвлэх бидний саналыг хүлээн авч судалгаа, шүүмжлэлт задлан шинжлэл, практик асуудлууд болон өнөөгийн улс төрийн тогтолцоонд шаардлагатай буй өөрчлөлтүүдийн талаарх стратегийн өргөн хүрээ бүхий анализтай хослуулсан илтгэлийг бидэнд ирүүлсэн нь талархалтай хэрэг болсон юм. Тэрбээр Монголын эдийн засгийн хөгжил, ардчиллын тогтвортой байдлыг харьцуулан Монголын ардчиллын ололт амжилт, мөн учирч буй бэрхшээл эрсдлийг авч үзжээ. Нэг талаас геополитикийн хувьд автократ Хятад, Орос хоёрын болон ардчилсан бус бүс нутгийн хөршүүдийн дунд хавчуулагдсан Монголын ардчилсан засаглалын цэцэглэлт, нөгөө талаас эрдэс баялгийн болзошгүй хараал, аюул, үр ашиг зэрэг нь хөрөнгийн тэгш бус байдал, хүн амын гуравны нэгийн дунд өсөн нэмэгдсээр буй ядуурал, төрийн эрх мэдлийн төлөө хөөцөлдөгсдийг дэмжсэн улс төрийн тогтолцоо, үндэсний хэмжээний олон салбар урт хугацаанд тогтвортой эдийн засгийн хөгжлийг дэмжсэн бус гагцхүү богино хугацааны баялгийн хувиарлалт хийж мөнгө төлөх бодлого явуулж байгаа зэрэг асуудлуудыг онцлон дурджээ. Эдийн засгийн өсөлтийн үр ашгийг тэгш хуваарилах, Монголын эдийн засгийн эрс өсөлтийн тогтвортой үргэлжлэлийг хангахад анхаарал хандуулах шаардлагатайг тэмдэглэж дүгнэхдээ Монголын ардчиллын зэрэг хүчинд өөдрөгөөр итгэж байгаагаа илэрхийлж үүнд улс төрчид, бодлого боловсруулагчдтай хариуцлага тооцох мэдээлэл бүхий иргэдийн ойлголт чухал байгааг илэрхийлсэн байна.

¹ Нээлттэй нийгэм хүрээлэнгээс зохион байгуулсан “Социализмын дараах Монголчууд” олон улсын хуралд тавьсан илтгэл. 2011 оны 6 дугаар сарын 28

Фрийдомхаусын газрын зураг дээр Монгол Улс яг л цэлэлзсэн хөх далайн дундах ганцаардсан ногоон арал шиг харагддаг. Евроазийн эх газрын дунд эрх чөлөөт бус улс орнуудаар хүрээлүүлсэн монголчуудын хувьд ардчилал, эрх чөлөөт нийгмийг байгуулах хүчтэй эрмэлзэл, ардчиллын чиглэлээр олсон ололт амжилтын шалтгаан юу байв гэдэг асуулт хүмүүсийн сонирхлыг зүй ёсоор татдаг.

Ардчилал ялах, оршин тогтнох, бэхжих, эсвэл ухралтад орж мөхөх шалтгааныг судлаачид олон хүчин зүйлтэй холбон тайлбарладаг. Тухайлбал, ардчилал хөгжсөн орнуудтай ойр зэргэлдээ орших газар зүйн ач холбогдолтой байрлал, улс төрийн түүхэн уламжлал, нийгэм-эдийн засгийн хөгжлийн түвшин, дундаж болон чинээлэг давхаргын нийт хүн амын дунд эзлэх хувийн жин зэрэг хүчин зүйлсийг ардчилал тогтох, бэхжин хөгжих нөхцөл хэмээн илүүтэй онцолдог.

Монголын ардчиллын шалтгаан, нөхцлийг судалсан эрдэмтэд, улс төр судлаачид сонирхолтой дүгнэлтүүд хийж, зарим нь Монголыг ардчилал тогтноход “хамгийн магадлал багатай” газар хэмээн бичиж байлаа.¹ Үнэхээр ч дээр дурдсан хэдэн нөхцлийг цэгнэж үзэхэд л Монгол Улс газарзүйн хувьд өрнө, дорнын ардчилсан орнуудаас тусгаарлагдмал, ардчилсан нийгэм байгуулж байсан түүхэн уламжлал хомс, ардчиллын үйл явц хүчээ авсан 1990-ээд онд нийгэмд ядуурал, ажилгүйдэл газар авч эдийн засгийн нөхцөл байдал социализмын дампуурлын дараах шокноос гараагүй, хүндхэн хэвээр байлаа. Монголын тухайн үеийн парламент, нийгэм тэр аяараа ардчилсан үзэл санаагаар амьсгалж, ардчилсан Үндсэн хуулийг баталж, мөрдөж эхэлсэн 1992 онд Монголд инфляц 325 хувьд хүрч байсныг дурдахад сонин байх болов уу. Энэ илтгэлд ардчиллын шалтгаан, нөхцөл гэж үздэг хүчин зүйлүүдийн дотроос эдийн засгийн хүчин зүйлийг сонгон авч

¹ Fish, M. Steven (Michael Steven), *Mongolia: Democracy Without Prerequisites*. Journal of Democracy - Volume 9, Number 3, July 1998, pp. 127-141

Монголын жишээн дээр хэрхэн бууж байгаад товч дүгнэлт хийхийг эрмэлзлээ.

Ардчилал тогтох шалтгааныг судалсан эрдэмтдийн дотор хүндтэй байр эзэлдэг Липсетийн бүтээлд эдийн засаг-нийгмийн хүчин зүйлсийг улс төрийн хөгжилтэй холбон тайлбарласан хэсэг сүүлийн 50 гаруй жилийн турш судлаачдын анхаарлыг татсаар ирсэн. Тэрээр эдийн засгийн хөгжил, түүний дотор нийт хүн амд дундаж давхаргынхны эзлэх хувь хэмжээ ардчилал ялж, бэхжихэд чухал үүрэгтэй гэж үзсэн байдаг.² Түүнээс хойшхи үеийн эрдэмтэд энэ асуудлыг гүнзгийрүүлэн судлахын сацуу ардчилал ялах шалтгаан, оршин тогтнож, бэхжихэд зайлшгүй шаардлагатай нөхцөл хоёрыг салган авч үзэх болжээ. Энэ хүрээнд зарим судлаачид эдийн засгийн хөгжил нь ардчилал ялж тогтох зайлшгүй шалтгаан бус, харин оршин тогтнож бэхжихэд зайлшгүй шаардагдах нөхцөл гэсэн дүгнэлт хийх болсон нь монголчууд бидний хувьд нэн хамааралтай, сонирхолтой асуудал болж байгаа юм. Эдийн засгийн өсөлт хэрхэн ардчиллыг бэхжүүлэх үндэс шалтгаан болж байгааг тайлбарлахдаа тэдгээр эрдэмтэд иргэдийн амьдрал нийтгээр дээшлэх, амьдралын түвшний ялгаа багасах, нийгмийн амьдрал улам олон талтай болж, түүнд иргэдийн оролцоо нэмэгдэх нөхцөл бүрддэгтэй холбосон байдаг.

Тэгвэл бид эдийн засгийн өсөлт бүхэн ийм үр дүн дагуулдаг уу гэдэг асуултад хариулах хэрэгтэй болно. Монгол Улсын эдийн засаг сүүлийн жилүүдэд тасралтгүй өсч, нэг хүнд ноогдох ДНБ-ний хэмжээ 90 оны дунд үеэс даруй 6-7 дахин өсч, 3500 ам.долларт хүрчээ. Тодорхой тоо дурьдвал, 1996 онд нэг хүнд ноогдох ДНБ-ний хэмжээ 292,8 мянган төгрөг байсан бол 2010 онд 3050,6 мянган төгрөг болж бүр 9 дахин өссөн байх юм.³ Гэсэн ч гурван монгол хүн тутмын нэг нь ядуу

² Lipset, Seymour M. 1959. Some Social Requisites of Democracy: Economic Development and Political Legitimacy. *American Political Science Review*. 1959

³ Үндэсний статистикийн хороо, Статистикийн эмхэтгэл 2011 он, “Макро эдийн

амьдарсан хэвээр байна. Ядуурал нь тэгш бус байдал, авилга, сонгуулийн булхай, луйврын үндэс болж, Монголын балчир ардчиллыг ганхуулах хортой хөрс болж ирлээ.

Өнөөдөр бидний өмнө 1990-ээд оны хүнд нөхцөлд байгуулж, буй болгож чадсан ардчилсан тогтолцоогоо цаашид хэвээр хадгалж, бэхжүүлж чадах уу гэдэг асуудал хамгийн чухлаар тавигдаж байна. Ардчилал зөвхөн улс төрийн тогтолцооны хувьд бусдаасаа зарим талаар давуу, хувь хүний эрх, эрх чөлөөний үнэт зүйлийг баталгаажуулах боломж олгодог гэдгээр төдийгүй хоёр их гүрний дунд орших Монгол Улсын хувьд бүрэн эрхт байдлаа хангах илүү сайн нөхцөл, улмаар үндэсний аюулгүй байдлын баталгаа болох утгаараа ийнхүү бидний анхаарлын төвд байгаа хэрэг юм.

Дэлхийн хэмжээнд эрчим хүчний эх үүсвэр хомсдох, үнэт металл, байгалийн баялгийн эрэлт хэрэгцээ нэмэгдэх хэрээр Монголын эдийн засагт уул уурхайн салбар хамгийн чухал үүрэг гүйцэтгэх болж, эдийн засаг ч улам хурдтай өсөх хандлагатай болж байна. Монголын төр засгаас нэг хүнд ноогдох ДНБ-ний хэмжээг дараагийн 10 жилд доод тал нь 5 дахин нэмэгдүүлэх зорилт тавьж байгаа. Байгалийн арвин их нөөц, гадаад зах зээл дэх өсөн нэмэгдэж байгаа эрэлтийг тооцон үзвэл цөөн хүн амтай Монгол улсын хувьд энэ нь бүтэхгүй зорилт биш юм.

Гэсэн ч хүмүүсийн дунд асуулт, эргэлзээ байсаар байна. Хамгийн гол асуулт бол эдийн засгийн өсөлтийн үр шимийг монголчууд нийтээрээ хүртэж, улмаар энэ нь иргэний нийгэм, иргэний оролцоо хөгжих, засаглал улам чадавхжих нөхцөл болж ингэснээр Монголд ардчилал улам бэхжих үндэс суурь тавигдах уу? Эсвэл байгалийн их баялагт дулдуйдсан гэнэтийн өсөлтийн үр шимийг цөөн улс төрч, олигархиуд өөрсөддөө таатайгаар ашиглаж, эрх мэдлээ үеийн үед хадгалах, хамгаалах

оролдлого хийж, энэ нь нийгэмд бухимдал, тогтворгүй байдлыг дэврээх, хүч хэрэглэх, улмаар ардчиллаас ухрах шалтгаан болох уу?

Хамгийн өөдрөг үзэлтэн ч хоёр дахь буюу илүү гутранги нөхцөл байдал Монголд үүсэхгүй гэж баттай хэлж чадах нөхцөл хараахан бүрдээгүй байна. Бидний хувьд хамгийн муу мэдээ бол байгалийн их баялагт суурилсан эдийн засгийн гэнэтийн өсөлт ардчиллын төлөвшилд муугаар нөлөөлдөг, тэр ч бүү хэл ардчиллаас ухрах нөхцөл, шалтгаан болж ирснийг олон улсын амьдрал дахь олон бодит жишээ ч, эрдэмтдийн судалгаа ч харуулж байна. Монгол Улс өнөөдөр баялгийн хараалд өртөх хамгийн өндөр магадлалтай, эгзэгтэй үе дээрээ байна гэж хэлэх бүрэн үндэстэй тийм нөхцөлд байна. Товчоор хэлбэл, Монголд ардчилал ялсан үйл явц улс төр судлаачдын сонирхол, гайхширлыг төрүүлсэн шиг энэ эгзэгтэй цаг үед Монголын ардчилал тэсч үлдэх эсэх асуудал дахиад улс төр судлаачид, сонирхогчдын анхаарлыг ихээхэн татаж байна.

Болгоомжлол төрүүлж байгаа асуудлуудын дотроос дараах хэдэн зүйлийг онцлон хөндөе.

Юуны өмнө, ядуурал буурахгүй, улмаар хүн амын дунд тэгш бус байдал газар авч байхад нийгэм дэхь зарим бүлгүүд үүнд хэвийн үзэгдэл мэт хандах болсон нь анхаарал татаж байна. Өнгөрсөн хэдэн удаагийн сонгуулийг эргэн харвал улс төрийн намууд энэ байдлыг залруулах эдийн засгийн оновчтой бодлого дэвшүүлж, амжилтад хүргэе гэхээс илүү ядуу сонгогчдын сэтгэхүй дээр “тоглож”, мөнгөний амлалтаар сонгуульд ялах, цаашилбал үр дүн муутай нийгмийн халамжийн бодлогоор аргацааж эрх мэдлээ улам бэхжүүлэх эрмэлзэл байгаа нь жирийн сонгогч, иргэдэд эргэлзээ төрүүлсээр байгаа юм.

Хоёрдугаарт, манайд өрнөж байгаа улс төрийн үйл явц зарим талаар санаа зовох үндэслэлийг улам тэлж байна. Ардчилал ялснаас хойшхи хугацаанд Монголын улс төрийн сонгуулиуд үндсэндээ бүгд мажоритар тогтолцоогоор явж

ирсэн бөгөөд сонгуулиас сонгуулийн хугацаанд тойрогтоо мөнгө тараах, популист арга хэмжээ хэрэгжүүлэх замаар гишүүд өөрсдийн байр суурийг бататгах аргыг сонгож ирсэн. Сонгуулийн тогтолцооноос үүдсэн гажуудал нь харамсалтай нь улс орны хэмжээний өргөн цар хүрээтэй бодлого явуулж, ядуурлыг бууруулах, эдийн засгийн аюулгүй байдал, хөгжлийн баталгааг хангах бус, “тойргийн улс төр” цэцэглэх нөхцлийг тавьж ирсэн. Өнөөдөр Монгол улсын эдийн засгийн аюулгүй байдлын ноцтой асуудал болж байгаа шатахууны хямрал нь шийдэгдэж чадахгүй байгаа нь тэдгээр олон том асуудлын нэг юм. Гэтэл өнөөдөр нөхцөл байдал ийм байсаар байтал, үүнийг сайтар мэдэж байгаа парламентын олонх мажоритар тогтолцоог дахин сонгож байгаа нь нөхцөл байдлыг улам төвөгтэй болгож байна.

Эдийн засгийн хөгжил, улс төрийн тогтолцооны харилцан уялдаа холбоог 135 орны жишээн дээр харьцуулан судалсан Презеворски нарын эрдэмтэд нэгэн сонирхолтой дүгнэлтэд хүрчээ. Ардчилал тогтож, бэхжин хөгжсөн, эсвэл замаасаа буцаж дарангуйлагч дэглэм рүү хальтурсан олон орны жишээнээс харахад нэг хүнд ноогдох дотоодын нийт бүтээгдэхүүн /ДНБ/-ий хэмжээ 6055 ам.доллараас дээш хэмжээнд хүрсэн нэг ч орон дарангуйлагч дэглэм рүү буцаж ороогүй байна. Үүний нэг адил ДНБ-ий үзүүлэлт дээрх хэмжээнд хүрсэн, хурдтай хөгжиж байгаа дарангуйлагч дэглэм ч удаан хугацаанд тогтвортой байдлаа хадгалах боломжтой гэж эрдэмтэд үзэж байна.¹

Монгол Улсын хувьд 2012-2016 он хурдтай өсөлтийн үе байх бөгөөд чухам энэ үед Монгол улс дээрх эрдэмтдийн босго болгон үзэж байгаа 6055 ам.долларын заагийг давна. Тиймээс олон улсын жишгийг харгалзан үзвэл чухам энэ хариуцлагатай үед Монголын улс төрийн нөхцөл байдал ямар

1 Prezeworski, Adam and Fernando Limongi. 1997. Modernization: Theories and Facts. *World Politics*. 49 155-183

байхаас Монголын ардчиллын цаашдын хувь заяа хамаарна гэж үзэх үндэстэй юм.

Ардчиллын ирээдүйд зовних бас нэгэн шалтгаан нь Монгол Улс эрчимтэйгээр халамжийн улс болж байгаа явдал юм. Төрийн зардал ДНБ-ий тэн хагас хувийг эзлэх болсныг энэ оны нэгдсэн төсвийн нийт орлого 3,304.6 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 42.2 хувь, уг орлогод нийцүүлсэн нэгдсэн төсвийн нийт зарлага 4,084.1 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 52.1 хувийг эзэлж буйгаас харж болно.² Иймээс Монгол Улс данхар том төртэй, хавтгайрсан халамжийн бодлоготой улс болж, энэ хэрээр Монголын эдийн засаг рахиттай хүүхэд шиг болж байна уу гэсэн сэтгэгдэл төрж байна. Нийгмийн хөгжилд төрийн оролцоо чухал боловч төрийн зардал ДНБ-ий 30 хувиас давсан үед эргээд эдийн засгийн өсөлтөө хязгаарлах, улмаар ажил эрхлэлтийг бууруулах, иргэдийн өөрийнхөө хүчинд найдан амьдрах эрмэлзлийг бууруулдгийг олон эмпирик судалгаа харуулдаг. Халамжийн эдийн засаг удаан хугацаанд амьдрах чадваргүйг бид зах зээлийн урт удаан хугацааны уламжлалтай Өрнөдийн орнуудын жишээн дээрээс харсан. Тиймээс Монголд халамжийн төр тогтнож байгаа нөхцөлд бидний хүсч байгаа олон тулгуурт чөлөөт эдийн засаг цэцэглэн хөгжино гэж найдахад төвөгтэй юм.

Эцэст нь дүгнэхэд, энэ богинохон илтгэлд Монголын ардчиллын хөгжилд нөлөөлөх геополитик, улс төр, нийгэм, соёл, эдийн засгийн олон хүчин зүйлүүдийн дотроос эдийн засгийн асуудлыг, түүний дотор улс төрийн ирээдүйд хамгийн нөлөөтэй гэж үзсэн цөөн асуудлыг хөндлөө.

Ойрын жилүүдэд Монголын ардчиллын хувь заяанд хамгийн хүчтэй нөлөөлөх хүчин зүйл бол эдийн засгийн өрнөл хөгжил яахын аргагүй мөн. Монголын улс төрийн намууд, улс төрчид, төр засаг эдийн засгийн бодлогоо хэрхэн

² Сангийн яамны вэб хуудас, <http://www.iltod.gov.mn/?p=805>

зөв тодорхойлж чадахаас улс орны ирээдүй шууд хамаарна. Халамжийн бодлогод дулдуйдаж эрх мэдлээ хамгаалахыг эрмэлзсэн, уул уурхайн орлогод найдаж эдийн засгийн бусад секторын хөгжлийг орхигдуулсан, мөнгөтэй цөөнхийн сонирхолд түлхүү үйлчилсэн улс төр эдийн засгийн бодлого удаан хугацаанд ноёрхох аваас бидний үндэсний эрх ашиг, бүрэн эрхт байдлын баталгаа гэж үзэж байгаа ардчиллын ирээдүй нэн бүрхэг болно.

Илтгэгч миний бие монголчуудын эрх чөлөөний мэдрэмж, улс үндэснийхээ төлөө чин эрмэлзэлд эргэлзэж байгаагүй, үүгээрээ ч улс орныхоо ирээдүйд өөдрөг итгэлтэй байдаг хүмүүсийн нэг. Тиймээс ч бидэнд тулгарч байгаа сорилтуудыг даван туулж чадна гэсэн итгэлтэй байдаг ч энэ нь тулгамдаж байгаа асуудлуудыг үл хайхран хойш тавих шалтгаан бус, харин ч туйлын анхааралтай, хариуцлагатай байх шаардлагатай гэж үздэгээ энд онцлон тэмдэглэе.